

“Даатгалын багц дүрэм”-ийн арван гуравдугаар хавсралт

## ДААТГАГЧИЙН ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

(шинэчилсэн найруулга)

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын төлөвлөгөөний тайлан, тэдгээрт тавигдах шаардлагыг тодорхойлох, биелэлтэд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)–ноос хяналт тавихтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Давхар даатгалын төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

2.1 Давхар даатгалын төлөвлөгөө нь давхар даатгалын стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

2.2 Давхар даатгалын стратеги төлөвлөгөө нь даатгагчийн бизнес төлөвлөгөө болон андеррайтинг, эрсдэлийн удирдлагын стратегитай уялдсан байна.

2.3 Даатгагчийн хэрэгжүүлж байгаа давхар даатгалын төлөвлөгөөг удирдлагаар хангах үндсэн нэгж нь Төлөөлөн Удирдах Зөвлөл/цаашид ТУЗ/байна. ТУЗ нь:

2.3.1 Давхар даатгалын төлөвлөгөө нь тухайн даатгагчийн санхүүгийн чадавх, бизнесийн төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын стратеги болон андеррайтингийн үйл ажиллагаатай уялдсан эсэхийг үнэлж, давхар даатгалын стратеги төлөвлөгөө болон давхар даатгалын жилийн төлөвлөгөөг батална;

2.3.2 Давхар даатгалын жилийн төлөвлөгөөний дагуу хэрэгжих үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт тогтвортой үргэлжлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг хүлээнэ;

2.3.3. Давхар даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор даатгагчийн төлбөрийн чадвар эсвэл аливаа зохицуулалтын үүргээ биелүүлэх чадавхад сөргөөр нөлөөлж болзошгүй асуудал үүсэх магадлалтай болохыг тогтоосон тохиолдолд тэр даруй Хороонд мэдэгдэх ба ТУЗ нь нэн даруй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.

2.4 Даатгагч нь хэрэгжүүлж байгаа давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах үндсэн нэгжтэй байна. Тус нэгж нь:

2.4.1 Давхар даатгалын үйл ажиллагааг хариуцах боловсон хүчний бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн, ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхойлно;

2.4.2 Нэгж нь тухайн байгууллагын санхүүгийн чадавх, бизнесийн төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын стратеги болон андеррайтингийн үйл ажиллагаатай уялдсан давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулна;

2.4.3 Нэгж нь давхар даатгалын стратегийг дор хаяж жил бүр хянан үзэх ба даатгагчийн нөхцөл байдал, эрсдэлийн удирдлагын стратеги, томоохон давхар даатгагчдын үйл ажиллагаа, андеррайтингийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд ноцтой өөрчлөлт гарсан тохиолдолд давхар даатгалын стратеги төлөвлөгөөг дахин боловсруулж ТУЗ-аар батлуулна;

2.4.4 Давхар даатгалын гэрээ байгуулах, түүний биелэлт, давхар даатгалын нэхэмжлэл, нөхөн төлбөр, эрсдэлийн байдал болон андеррайтингийн үйл ажиллагаа нь байгууллагын бодлого, давхар даатгалын төлөвлөгөөний дагуу явагдаж буй эсэхийг тогтмол хянаж, үүссэн асуудлын учир шалтгааныг зохих хяналт шалгалтын дагуу тогтоон, зохих түвшинд шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

### **Гурав. Давхар даатгалын төлөвлөгөө, түүнд тавигдах шаардлага**

3.1 Давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

3.1.1 Давхар даатгалын төлөвлөгөөний зорилго, зорилт;

3.1.2 Даатгагчийн хүлээж болох нийт эрсдэлийн дээд хязгаарыг тогтоох, удирдах болон хянах үйл ажиллагааны талаар;

3.1.3 Давхар даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт, тайлагнал, дотоод хяналтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх арга замын талаар;

3.1.4 Давхар даатгалын үйл ажиллагааг хариуцах боловсон хүчний нөөцийг тодорхойлж, түүний хүлээх үүрэг, хариуцлагын талаар;

3.1.5 Хамтран ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн найдвартай, хэвийн үйл ажиллагааны талаар үнэлэлт, дүгнэлт гаргаж, тэдгээрт хүлээлгэх эрсдэлийн дээд хэмжээг тодорхойлсон талаар;

3.1.6 Давхар даатгагч болон давхар даатгалын зуучлагчийн зохицуулагч байгууллага болон харьяалагдах улсын нэрсийн жагсаалт;

3.1.7 Давхар даатгалын үйл ажиллагаанаас үүдэн гарч болох санхүүгийн эрсдэлүүдийг /төлбөрийн чадварын эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, зээлийн эрсдэл гэх мэт/ даатгагчийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээ /ORSA/ зэрэг зохих аргачлалын дагуу тодорхойлж, тэдгээрийг зохицуулах арга хэрэгслийн талаар;

3.1.8 Даатгалын бүтээгдэхүүн /гэнэтийн ослын, үл хөдлөх хөрөнгийн даатгал гэх мэт /тус бүрээр эрсдэл төвлөрүүлэх түвшинг/ газарзүйн бүсчлэл болон холбогдох салбарын хүрээнд/ тодорхойлж, удирдах болон хянах үйл ажиллагааны талаар;

3.1.9 Давхар даатгалын зуучлагчаар дамжуулан давхар даатгалд хамрагдах шалтгаан, түүнийг сонгох шалгуур, түүний үүрэг хариуцлагын талаар;

3.1.10 Даатгалын улирлын шинжтэй үйл ажиллагаа болон хохирол хамгийн өндөр байх үечлэлийг тодорхойлж, тухай бүрд давхар даатгалын төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлсон талаар;

3.1.11 Факультатив, гэрээт давхар даатгал болон бусад давхар даатгалын хэлбэрт хамрагдах шалгуур үзүүлэлтийн талаар;

3.1.12 Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний онцлогтой уялдуулан хувь оролцоотой /*proportional*/ болон хувь оролцоогүй /*non-proportional*/ давхар даатгалын гэрээ байгуулахад баримтлах шалгуур, даатгалын хэлбэрийн талаар;

3.2 Давхар даатгалын жилийн төлөвлөгөөг даатгагчийн давхар даатгалын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр боловсруулан, батлуулах ба дараах зүйлсийг тусгана.

3.2.1 Давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд заасны дагуу даатгагчийн хүлээж чадах нийт эрсдэлийн хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээ;

3.2.2 Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн тус бүрээр өөрт үлдэх эрсдэлийн хэмжээ;

3.2.3 Хамтарч ажиллах давхар даатгагчийн жагсаалт, тэдгээрийн хүлээх эрсдэлийн хэмжээ;

3.2.4 Даатгалын гэрээ болон давхар даатгалын гэрээгээр хамрах эрсдэлүүдийн зөрүүг зохицуулах арга зам;

3.2.5 Давхар даатгалын нөхөн төлбөр болон хохирлын нөхөн төлбөрийг төлөх үйл ажиллагаа нь цаг хугацааны хувьд хоорондоо тохирохгүй байх нөхцөлд бэлэн мөнгөний урсгалыг зохицуулах арга зам;

3.2.6 Факультатив давхар даатгал болон гэрээт давхар даатгалд хамруулах даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн давхар даатгалын хэмжээ.

#### **Дөрөв. Давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулахад баримтлах зарчим**

4.1 Даатгагч нь өөрт үлдээх гэрээний эрсдэлийн дээд хэмжээнд тохирсон хөрөнгийн чадвартай байх ба хэрэв даатгалын нэг болон хэд хэдэн удаагийн тохиолдол болоход даатгалын гэрээний дагуу даатгуулагчийн гэрээгээр хүлээсэн эрсдэлийн хариуцлагын хэмжээ нь өөрийн хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээнээс давахаар байвал даатгагч тухайн даатгалын эрсдэлийн хариуцлагыг давхар даатгагчид заавал даатгуулсан байх;

4.2 Даатгалын тодорхой нэг зүйлийн эрсдэлийг давхар даатгуулах гэрээний нөхцөл нь анхны даатгалын гэрээний нөхцөлөөс буурахгүй буюу илүү таатай нөхцөлтэй байх;

4.3 Даатгагч нь давхар даатгагчид шилжүүлэх гэрээний эрсдэлийн дээд хэмжээнд тохирсон хөрөнгийн чадвартай эсэхийг тодорхойлсны дагуу давхар даатгагчийн эрсдэл төвлөрөлтийн түвшинг харгалзан, даатгалын эрсдэлээ тараан хуваарилах ба давхар даатгагчийн хүлээж буй гэрээний эрсдэл нь тухайн давхар даатгагчийн эрсдэлийн дээд хэмжээнээс хэтэрч буй эсэхийг тогтмол хянаж, шаардлагатай зохицуулалтыг хийх;

4.4 Даатгагч хамтран ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийг сонгох үндэслэл, шаардлагыг давхар даатгалын төлөвлөгөөнд тодорхой тусгасан байх;

4.5 Хорооноос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхээр Хороонд бүртгэгдсэн давхар даатгалын зуучлагчтай хамтран ажиллах;

4.6 Гадаад улсад байгуулагдаж, харьяалагдах орны зохицуулалтын байгууллагын хяналтад байдаг, Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг, эсхүл түүнийг төлөөлсөн этгээд нь дараах үнэлгээтэй байх;

1/ “A.M.Best Company”-ийн “А”-аас дээш;

2/ “Standard and Poors”, “Filtch Group”-ийн “BBB”-ээс дээш;

3/ “Moody’s Corporation”-ийн “ВАА”-аас дээш;

4/ “Rating Agency Expert RA”-ийн “А”-аас дээш;

4.7 Даатгагч нь давхар даатгагчид шилжүүлэх даатгалын эрсдэлийн хэмжээг тогтоохдоо давхар даатгагч тус бүрийн гэрээний үүргээ биелүүлэх санхүүгийн чадавх, давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн туршлагыг үнэлсэн тооцоонд суурилсан байх.

## **Тав. Төлөвлөгөөг тайлагнах**

5.1 Давхар даатгалын стратеги төлөвлөгөөг батлуулснаас хойш 10 хоногийн дотор, давхар даатгалын хөтөлбөрийг өмнөх оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

5.2 Хороо даатгагчийн давхар даатгалын стратеги төлөвлөгөө энэ журмын шаардлагыг хангасан гэж үзвэл давхар даатгалын төлөвлөгөөг Хороонд ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор Хорооны хяналт шалгалт, зохицуулалтын асуудал эрхэлсэн газар танилцаж, даатгагчид хариуг хүргүүлнэ. Хэрэв давхар даатгалын стратеги төлөвлөгөөг шаардлага хангаагүй гэж үзвэл Хороо уг төлөвлөгөөг буцаах үндэслэлийн хамтаар даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

5.3 Даатгагчид нь энэ журмын дагуу Хорооноос хянаж, шаардлага хангасан гэж үзсэн давхар даатгалын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах ба давхар даатгалын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ тухай хүсэлтээ Хороонд бичгээр мэдэгдэж, шинэчлэгдсэн төлөвлөгөөг ирүүлэх ба энэ журамд заасны дагуу хянаж, даатгагчид хариу хүргүүлнэ.

5.4 Хорооны шаардлага хангасан гэж үзсэн давхар даатгалын төлөвлөгөөний үр дүнгийн гүйцэтгэл, нэмэлт, өөрчлөлт орсон эсэхийг ТУЗ тогтмол хянаж, баталгаажуулах ба жил бүрийн 3-р сарын 01-ний өдрийн дотор давхар даатгалын төлөвлөгөөний тайланг боловсруулж Хороонд ирүүлнэ.

5.5 Давхар даатгалын төлөвлөгөөний тайланд давхар даатгалаар шилжүүлж буй эрсдэлийн хэмжээ, хураамж, нөхөн төлбөр, давхар даатгалын үйл ажиллагааны үр дүнг тодорхой тусгахаас гадна дараах материалыг хавсаргана. Үүнд:

5.5.1 Даатгагчийн давхар даатгалын үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт, шалгалтын тайлан, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаарх танилцуулга, тодруулга;

5.5.2 Давхар даатгалын гэрээний хуулбар, тэдгээрт оруулсан өөрчлөлтүүд;

5.5.3 Давхар даатгалын гэрээ болон давхар даатгалын гэрээний нөхцөлийн зөрүүний талаарх мэдээлэл;

5.5.4 Давхар даатгагч даатгалын эрсдэлийг даатгах болсныг баталгаажуулсан баримт буюу давхар даатгалын гэрээний нөхцөлийн хураангуй болон шаардлагатай бусад мэдээллийг тусгасан “Давхар даатгалын баталгаа”(reinsurance slip)-ны хуулбар;

5.5.5 Давхар даатгалын зуучлагчаас даатгагчид ирүүлсэн давхар даатгалын гэрээ байгуулагдсаныг нотлох баримт буюу давхар даатгалын гэрээний нөхцөлийн хураангуйг тусгасан “Давхар даатгалын мэдэгдэл”(cover note)-ийн хуулбар;

5.5.6 Давхар даатгалын хугацаат төлбөрийн баримтуудын хуулбар(төлбөрийн шилжүүлэг хийгдсэн тохиолдол бүрт);

5.5.7 Энэ журмын 1 болон 2 дугаар хавсралт загварын дагуу гаргасан “Давхар даатгалын гэрээний мэдээлэл” /Даатгагч энэ мэдээллийг Хороонд цаасаар ирүүлэхээс гадна цахим хэлбэрээр ирүүлнэ./

5.5.8 Бусад материал.

5.6 Давхар даатгалын төлөвлөгөөнд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Хороо нэмэлт материал шаардаж болно.

### **Зургаа. Хяналт, хариуцлага**

6.1 Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд журмыг зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-н 1 дүгээр хавсралт

**МАЯГТ СЗХ04153.Факультатив давхар даатгалын гэрээний мэдээлэл**

Даатгагчийн нэр .....

20...оны ... сарын ...-ны өдөр

№	Огноо	Даатгалын гэрээний дугаар	Даатгалын бүтээгдэхүүн	Даатгалын үнэлгээ	Даатгалын хураамж	Давхар даатгалын хураамж	Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх*			Давхар даатгагч	Давхар даатгалын нөхцөл**				Эрсдэлийн хувь***		Хариуцлагын хязгаар****		Шимтгэл /Commisi on/	Давхар даатгалд ногдох нөөц сангийн хэмжээ	Нийт нөхөн төлбөр	Үүнээс: Давхар даатгагча ас төлсөн нөхөн төлбөр	
							Шууд	Дотоодын зуучлагч	Гадаадын зуучлагч		Хувь тэнцүүлсэн /proportional/ share	Хувь тэнцүүлээгүй Stop loss	Excess of loss	Даатгагч хариуцах хувь	Давхар даатгагч хариуцах хувь	Даатгагч хариуцах дээд хэмжээ	Давхар даатгагч хариуцах дээд хэмжээ						
																		12					13
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	
		Нийт																					

Маягт нөхөх заавар:

\* Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх- даатгалын зуучлагчаар дамжуулсан тохиолдолд зуучлагч компанийн нэрийг бичих; Даатгагч давхар даатгагчтай шууд гэрээ байгуулсан тохиолдолд багана 8 ("шууд")-г сонгох ʘ

\*\* Давхар даатгалын нөхцөл- давхар даатгалын гэрээний нөхцөлийг сонгох ʘ

\*\*\*Эрсдэлийн хувь хэмжээ- Давхар даатгагчтай quota share, surplus share нөхцөлөөр гэрээг хийсэн тохиолдолд даатгагч болон давхар даатгагчид хариуцах хувь хэмжээг бөглөх. Хэрэв хэд хэдэн давхар даатгагч оролцох тохиолдолд хариуцах хэмжээг тус бүрээр мөр нэмэх.

\*\*\*\*Хариуцлагын хязгаар- Давхар даатгагчтай stop loss, excess of loss нөхцөлөөр давхар даатгалын гэрээг хийсэн нөхцөлд даатгагч, давхар даатгагчийн хариуцлагын дээд хязгаарын хэмжээг бичих

ТАЙЛАН ГАРГАСАН: .....

(Албан тушаал)

(Гарын үсэг)

(Овог, нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20... оны ... сарын... өдөр

“Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд  
тавигдах шаардлага”-ын 2 дугаар хавсралт

**МАЯГТ СЗХ04154.Гэрээт давхар даатгалын гэрээний мэдээлэл**

Даатгагчийн нэр.....

20... оны ... сарын...-ны өдөр

Огноо	Даатгалын бүтээгдэхүүн	Нийт хураамж	Давхар даатгалын хураамжийн төлөх нөхцөл		Даатгалын хураамжийн дүн		Давхар даатгагч компанийн нэр	Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх*			Даатгалын шимтгэлийн нөхцөл**			Даатгалын нөхцөл***					Эрсдэл хариуцах хувь****		Хариуцлагын хэмжээ*****		Нөхөн төлбөрийн дүн		Давхар даатгалд ногдох нөөц сангийн хэмжээ
			Нэг удаа төлөх	Тухай бүр төлөх	Нийт хураамж	Давхар даатгалын хураамж		Шууд	Дотоодын зуучлагч	Гадаадын зуучлагч	/Sliding scale/	/Loss corridors/	/Profit commission/	/pro-rata/		/non-proportional/			Даатгагч	Давхар даатгагч	Даатгагч хариуцах дээд хэмжээ	Давхар даатгагч хариуцах дээд хэмжээ	Нийт нөхөн төлбөр	Давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөр	
														quota share	surplus share	Stop loss	Excess of loss	catastrophic loss							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
<b>Нийт дүн*****</b>																									
* Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх- даатгалын зуучлагчаар дамжуулсан тохиолдолд зуучлагч компанийн нэрийг бичих; Даатгагч давхар даатгагчтай шууд гэрээ байгуулсан тохиолдолд багана 9 ("шууд")-г сонгох ʘ																									
** Даатгалын шимтгэлийн нөхцөл- Хэрэв даатгагч шууд давхар даатгалын компанитай гэрээ байгуулсан тохиолдолд тохирох баганад нийт шимтгэлийн хэмжээг бичих																									
*** Давхар даатгалын нөхцөл- давхар даатгалын гэрээний нөхцөлийг сонгох ʘ																									
**** Эрсдэлийн хариуцах хувь- Давхар даатгалыг "quota share", "surplus share" нөхцөлөөр хийсэн тохиолдолд "эрсдэлийн хариуцах хувь" ( багана 20,21)-г харгалзан бөглөнө.																									
***** Хариуцлагын хэмжээ- Давхар даатгалыг "stop loss", "excess of loss" нөхцөлөөр хийсэн тохиолдолд " хариуцлагын хэмжээ"(багана22,23)-г харгалзан бөглөнө.																									
***** Нийт дүн- тайлант хугацаа тус бүрийн нийт дүн гаргана.																									